



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/03

Хөхбүрд

Г Өвөл хаврын хурдан морины уралдаанд  
18 нас хүртэлх насны хүүхдээр хурдан  
морь унуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргааны, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2.1, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаанд 18 нас хүртэлх насны хүүхдээр хурдан морь унуулахыг хориглосугай.

2.Энэ захирамжийг олон нийтэд сурталчилна таниулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, зөрчил гарсан үед шуурхай арга хэмжээ авч ажиллахыг багийн Засаг дарга нар, Цагдаагийн алба хаагчид, Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан, Сургуулийн нийгмийн ажилтан, Морин спорт уяачдын холбоонд тус тус үүрэг болгосугай..

3.Хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Гансүх)-д үүрэг болгосугай

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн “Өвөл, хаврын хурдан морины уралдааныг хориглох тухай” А/28 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

Т.БЯМБАДОРЖ

642501321

